


САР ХАРИУЦСАН АЛБА, ТАСАГ НЭГЖИЙН 2026 ОНЫ 6-Р САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026.06.30

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хувь
1	Цусны Донорын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	“Цусны Донорын Дэлхийн Өдөр”-ийг “Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч амьдрал бэлэглэе” уриан дор ЭМГазар, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар ,УЗХороо, НЭ-ийн алба,тасгууд,сувилахуйн алба Цусны Салбар Төв хамтран зохион байгууллаа. Өдөрлөгт: - НЭ-ийн захирал Б.Мөнхбат - Дархан-Уул аймгийн УЗХ-ны дарга Б.Отгонбаяр - ЦСТ-ийн эрхлэгч эмч Ч.Батсүрэн - НЭ-ийн Сувилахуйн албаны дарга С.Мөнхцолмон - ЭМГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтан Б.Эрдэнэбилэг нарын удирдлагууд оролцлоо. Өдөрлөгт 60 гаруй ахмад болон хүндэт донорууд, идэвхтэн донорууд НЭ-ийн тасгуудын ахлах сувилагч, сувилагч нар хамтран оролцлоо.  НЭ-ийн нийт сувилагч нарын төлөөлөл баярт хүрэлцэн ирж байгаа доноруудыг угтан авч,хүндэтгэл үзүүллээ.	100%
2	“ Ёс зүйн алдаа таныг бүрэн илэрхийлэхгүй буюу ёс зүйн алдаанд хүргэдэг гадаад хүчин зүйлс”	ЁЗХХ –ны эмч Б.Төрмөнх Нийт эмч эмнэлгийн ажилчдад зориулсан “Ёс зүй харилцаа хандлага”, “Эмнэлзүйн харилцаа”, “Стресс менежмент” гэсэн 4 төрлийн сэдвээр цуврал сургалтууд зохион байгуулж эмч эмнэлгийн ажилчид идэвхитэй хамрагдлаа.	90%
3	“Эмнэлзүйн харилцаа” сургалт зохион байгуулах		90%
4	“Стресс менежмент сургалт зохион байгуулах”		90%
5	“Итгэл үнэмшлээс хандлага, хандлагаас сэтгэлгээ,		90%

	сэтгэлгээнээс хувь тавилан, бүрэлдэн бий болохуй” сургалт зохион байгуулах		
6	“Сувилахуйн цахим түүх хөтлөлт, түүнд гарч буй алдаа тохиолдолд суурилсан сургалт”	Сувилахуйн алба нь Эрүүл мэндийн яамны дэргэдэх “Сувилгааны загвар түүх боловсруулах” ажлын хэсэгтэй хамтран “Цахим сувилахуйн түүх хөтлөлтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж алдаанд суурилсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар сувилахуйн тэмдэглэл хөтлөх олон улсын жишиг, аргачлалыг танилцуулж, сувилахуйн түүх хөтлөлтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, нийтлэг алдаа, сайжруулах чиглэлүүдэд тулгуурласан мэдээлэл, зөвлөмжийг хүргэлээ.Сургалтыг ажлын хэсгийн гишүүн, Сувилахуйн зөвлөх зэрэгтэй, СУ-ны магистр П.Наранцэцэг удирдан явуулсан бөгөөд нийт 143 сувилагч, мэргэжилтнүүд хамрагдсан. 	100%
7	Хөдөлгөөн эрүүл мэнд” өглөөний алхалт зохион байгуулах	Хөдөлгөөн эрүүл мэнд- Өглөөний алхалт зохион байгууллаа. Алхалтанд шугаман бүжгийн холбоо, ЭМГ хамтран дасгал хөдөлгөөн зааж алхалт хийсэн. Хамрагдсан 30 	90%
8	Гэдэсний халдвараас сэргийлье” өдөрлөг, цахим сурталчилгаа зохион байгуулах	Гэдэсний халдвараас сэргийлэе өдөрлөгийн хүрээнд богино хэмжээний контент зөвлөгөө хийж цахим хуудсанд байршуулав. Зуны халуун өдрүүдэд бага насны хүүхдүүдийн дунд гэдэсний цочмог халдварт өвчин (суулгалт, бөөлжилт) элбэгшдэг. Энэ үед хүүхэд богино хугацаанд их хэмжээний шингэн алдаж, бие нь сульддаг тул ◆ХОРОСОЛ уулгах нь хамгийн үр дүнтэй анхны тусламж юм. Анхаарах зүйлс: Хоросолыг хэзээ ч буцалж буй халуун усанд хийж болохгүй (найрлага дахь аминдэм, давс нь чанараа алдана). ◆ Найруулсан хоросолыг тагтай саванд хийж, зөвхөн 24 цаг ашиглана. Хугацаа хэтэрсэн бол асгаж, шинийг	90%

		найруулаарай. Хүүхэд уухгүй байвал чихэргүй хярам, хярамын шөл, буцалсан ус уулгаж болно.	
9	Гепатитын дэлхийн өдрийг угтуулан 2 сарын аян зохион байгуулах	Гепатитийн дэлхийн өдрийг угтуулан Дархан Цахилгаан Түгээх Сүлжээний ажилтан албан хаагчид эрүүл мэндийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдлаа. Халдвартын тасгийн эмч, мэргэжилтнүүд болон НЭМ-ийн ажилтан, “ Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн нийт ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт, үйл ажиллагааг элэгний эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан. Үүнд: 👤💰 Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт: "Элэгний В, С вируст гепатитийн халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр халдвартын тасгийн эрхлэгч эмч Ө.Хишигсүрэн сургалт хийлээ. Түргэвчилсэн оношилгоо: Элэгний В, С вирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулав. Шинжилгээгээр гепатитын С вирусын халдварын тохиолдлыг эрт шатанд нь илрүүлж, дараагийн шатны нарийвчилсан оношилгоо, эмчилгээнд чиглүүллээ. 📌 Дархлаажуулалт: Элэгний В вирусын халдвараас найдвартай хамгаалах В вирусын эсрэг вакцинд хамруулан 🏠 Гарын авлага, зөвлөмж тараан өглөө. ✔Вируст гепатит нь шинж тэмдэггүйгээр элгийг гэмтээдэг "чимээгүй аюул" тул эрт илрүүлж, вакцинжуулснаар та өөрийгөө болон хайртай хүмүүсээ ирээдүйд учрах эрсдэлээс хамгаалж чадна. ✨👤Эрүүл мэндийнхээ төлөө идэвхтэй хамрагдсан "Цахилгаан түгээх сүлжээ"-ний хамт олондоо эрүүл энхийг хүсээ! Эрүүл элэг – Эрт илрүүлгээс эхтэй.	90%

		 	
10	Нийт нэгдсэн эмнэлгийн алба хаагч нарт хууль эрхзүйн мэдлэг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Нэгдсэн эмнэлгийн удирдлагын баг аймгийн прокурорын газартай хамтран албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хуулийн аян”-ыг хүрээнд Дархан-Уул аймгийн Прокурорын Газрын ерөнхий прокурор Б.Эрхэмбаатар , хяналтын прокурор Т.Дэлгэрсайхан хүрэлцэн ирж авлига, авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлын талаар бодит кейс, тохиолдолуудад тулгуурласан сонирхолтой сургалтыг нийт эмч нарт зохион байгууллаа.  	100%
11	Тоног төхөөрөмжийн ээлжит сургалт зохион байгуулах	Дархан –Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албанаас энэ сарын төлөвлөгөөт сургалтыг инженер техникийн албатай хамтран зохион байгууллаа. Тоног төхөөрөмжийн инженер Б.Рэнчинмядаг, С.Сумъяабал нар сувилагч, тусгай мэргэжилтэн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ашиглалтын онол дадлагын сургалтыг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд зохион байгууллаа. Энэхүү сургалт нь эмнэлгийн тоног төхөөрөмжийг зөв, аюулгүй ашиглах ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн цогц сургалт болдог бөгөөд танхим болон ажлын байранд онол, дадлага хэлбэрээр зохион байгуулагддаг.  	95%

12	“Цэвэр хот” аяны хүрээнд нэгдсэн эмнэлгийн гадна талбайд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Цэвэр хот шарилжгүй Дархан аяны хүрээнд сар болгоны баасан гарагт бүх тасаг нэгжүүд гадна талбайн хуваарьт талбайн хэсгээ цэвэрлэж хэвшсэн ба шарилж хадаж зөөж хаяв Нэгдсэн эмнэлгийн тасаг нэгж болон албадууд идэвхитэй хамрагдлаа.   	95%
----	--	--	-----

2026 оны 06 дугаар сар хариуцсан тасгууд НЭ-ийн алба тасаг нэгжтэй хамтран 14 ажил төлөвлөснөөс 2 ажил хэрэгжээгүй нийт 12 ажил хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь 93.3%

Тайлан бичсэн: Хагалгааны нэгдсэн тасаг,Захиргаа, МТА